



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 28

Эрдэнэт

“Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк”  
ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлд  
өөрчлөлт оруулах, 2017 оны төсөв,  
төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.4 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтын ёсоор, 2017 оны төсөв, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. “Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан төсөв, төлөвлөгөөг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд явуулахыг тус байгууллагын захирал Г.Энхбаярт үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* Л.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100015